

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНГИЙН САЙД,  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 10 дүгээр  
сарын 7-ний өдөр

Дугаар А-498/2015, 10/07/2015, 296

Улаанбаатар

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2014 оны "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай" 69 дүгээр тогтоолын хавсралтын 3.2 дахь хэсэг, 2015 оны "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай" 12 дугаар тогтоолын хавсралтын 7.1, 7.2, 7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтийг зохион байгуулахыг Монголбанк (Н.Золжаргал), Сангийн яам (Б.Болор), Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам (Л.Гантөмөр), Санхүүгийн зохицуулах хороо (З.Нарантуяа)-нд тус тус даалгасугай.



Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Боловсрол, соёл,  
шинжлэх ухааны сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын  
2015 оны ..... дугаар сарын .....-ний өдрийн .....  
дугаар хамтарсан тушаалын хавсралт

## Агуулга

Товчилсон үгийн тайлбар .....	2
<b>Нэг. Хөтөлбөрийн баримт бичиг .....</b>	<b>3</b>
1.1 Хөтөлбөрийн тухай.....	3
1.2 Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага.....	3
1.3 Дэлхийн хөгжлийн чиг хандлага	6
1.4 Санхүүгийн мэдлэгийн талаар тодорхойлолт .....	8
1.5 Хөтөлбөрийн ач холбогдол.....	8
1.6 Хөтөлбөрийн алсын хараа болон зорилт.....	9
1.7 Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим.....	9
1.8 Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүд .....	9
1.9 Хөтөлбөрийн хүрээнд мэдлэг олгох сэдвүүд.....	10
1.10 Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт, <u>тайлагнал</u> .....	10
1.11 Хөтөлбөрийн хүрэх үр дүн.....	11
1.12 Хөтөлбөрийн санхүүжилт.....	11
1.13 Хөтөлбөрийн үр дүнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ .....	11
<b>Хоёр. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа .....</b>	<b>13</b>
2.1 Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ .....	13
2.2 Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх дэлгэрэнгүй арга хэмжээний төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт.....	18

## Товчилсон үгийн тайлбар

БСШУЯ-Боловсрол,соёл, шинжлэх ухааны яам

ЕБС-Ерөнхий боловсролын сургууль

МБ-Монголбанк

МБХ-Монголын банкны холбоо

МУИС-Монгол Улсын их сургууль

МХБ-Монголын хөрөнгийн бирж

НТБҮТ-Насан туршийн боловсролын үндэсний төв

ОСХТТТ-Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл

ОХУ-Оросын Холбооны Улс

СЗХ-Санхүүгийн зохицуулах хороо

СЯ-Сангийн яам

УИХ-Улсын их хурал

ҮСХ-Үндэсний статистикийн хороо

ХАХНХЯ-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам

ЭЗБХ-УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо

ЭЗХАХБ-Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага

ЭЗС-Эдийн засгийн сургууль

# ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР 2016-2021

## НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН БАРИМТ БИЧИГ

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал нь иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах, бүх нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах гэсэн хоорондоо нягт уялдаа бүхий зорилтуудыг хэрхэн ханган хэрэгжүүлж байгаагаар тодорхойлогддог. Эдгээрийн нэг болох санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх энэхүү асуудал нь тухайн хүний нас, орлого зэргээс хамаарахгүйгээр чухал давуу талуудыг бий болгож байдаг. Учир нь санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэх мэдлэг, ур чадвар нэмэгдсэнээр хувь хүний санхүүгийн аливаа эрсдэлээс сэргийлэх боломж нь нэмэгддэг. Санхүүгийн өндөр мэдлэг нь тухайн хувь хүнд болон түүний хамаатан садан, гэр бүлийн хүрээнд боломжуудыг бий болгож, зорилго болон санхүүгийн эрх чөлөөнд хүрэхэд нь цаашлаад нийгмийн эдийн засгийн эрүүл мэндэд ч эерэг байдлаар нөлөөлдөг ач холбогдолтой.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь оролцогч талуудын хамтын ажиллагааны тэнцвэртэй байдлыг хангаж, авч буй арга хэмжээ, үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэн шаардлагатай арга хэмжээнд төвлөрөх боломжийг олгох зэрэг давуу талыг бий болгодог. Тус хөтөлбөр хэрэгжсэнээр иргэдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн зөв шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжлийг дэмжих боломжтой болно.

### 1.1.Хөтөлбөрийн тухай

Монголбанкнаас санаачлан санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүлж, Сангийн яам, Боловсрол,соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоо, Монголын даатгагчдын холбоо, Хадгаламжийн даатгалын корпораци, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, холбоод, их дээд сургуулиудтай хамтран Дэлхийн банкны тусламжтайгаар удаа дараагийн уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнд энэхүү хөтөлбөрийг боловсрууллаа.

Хөтөлбөрийг боловсруулахад дэлхийн хөгжлийн чиг хандлага, олон улсын туршлага төдийгүй өөрийн орны онцлог байдал, хүн амын санхүүгийн боловсролын түвшинг харгалзан үзэж хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл, зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг тодорхойлов.

### 1.2.Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага



Сүүлийн жилүүдэд банк, санхүүгийн салбарын өсөлт эрчимжиж, хүн амын дунд банкны харилцах данс, хадгаламж зээлийн үйлчилгээ зэрэг энгийн санхүүгийн бүтээгдэхүүнийг хэрэглэх нь эрс нэмэгдсэн. Хэдий тийм боловч иргэдийн дунд санхүүгийн

мэдлэг, санхүүгийн бүтээгдэхүүний талаар ойлголт дутмаг байгаагаас өөрсдийн хэрэгцээнд тохирсон бүтээгдэхүүн сонгож, урт хугацааны санхүүгийн шийдвэр гаргахдаа хүндрэлтэй тулгарах асуудал байсаар байна. Энэ нь тухайн өрх гэрийн санхүүгийн байдлаас гадна урт хугацаанд санхүү, эдийн засгийн системийн тогтвортой байдалд нөлөөлдөг. Иймээс цаашид санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн сахилга батыг өндөржүүлэх, шударга өрсөлдөөнийг бэхжүүлэх зорилгоор санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэж байгаа харилцагчдын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх шаардлага бий болж байна.

Дэлхийн банкнаас 2012 онд Монгол Улсын санхүүгийн салбар дахь бүтээгдэхүүн үйлчилгээг хүртэж буй харилцагчдын эрх ашгийг хамгаалж буй байдал болон тэдгээрийн эдийн засаг, санхүүгийн мэдлэг, боловсролын өнөөгийн байдлыг олон улсын түвшинтэй харьцуулсан судалгаа хийсэн ба уг судалгаанд Монголын эрх бүхий байгууллагуудаас харилцагчдын эрх ашгийг хамгаалж буй байдал болон харилцагчдын банк санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдлэг дутмаг байгаа талаар дүгнэжээ.

Судалгааны тайлангаас<sup>1</sup> харахад, хүн амын дийлэнх хэсэг нь ямар нэг байдлаар санхүүгийн бүтээгдэхүүний талаар мэдээлэлтэй, энгийн тооцон бодох үйлдлүүдийг сайтар мэдэж байгаа боловч ирээдүйд хийх хөрөнгө оруулалт, хадгаламж зэрэг санхүүгийн шийдвэрийн талаар ойлголт багатай байна. Тухайлбал, судалгаанд хамрагдагсдын 97 хувь нь энгийн тооцон бодох үйлдлүүдийг хийж чадаж байсан ба 86 хувь нь даатгалын бүтээгдэхүүний зорилгын талаар ойлголттой байсан боловч, 30 орчим хувь нь хүүгийн талаар, 60-аас дээш хувь нь инфляци хадгаламжид нь хэрхэн нөлөөлөх талаар ойлголтгүй байжээ.

Монгол Улсын хувьд, санхүүгийн боловсролтой байх эсэхэд хүйсийн ялгаа бага байгаа үзүүлэлттэй байсан. Хот суурин газрын иргэдийн санхүүгийн боловсрол харьцангуй өндөр байсан бол Баян-Өлгий, Ховд зэрэг алслагдсан аймгуудын хувьд мэдээлэл авах боломж бага зэргээс үүдэн санхүүгийн ерөнхий мэдлэг бага байна. Өмнөговь, Дорноговь гэсэн уул уурхайн салбар хөгжиж буй, хилтэй ойр аймгуудын хувьд санхүүгийн ерөнхий мэдлэг хот суурин газартай ойролцоо түвшинд байжээ. Мөн орлогын түвшин өндөр, ажил эрхэлдэг байхын хэрээр санхүүгийн мэдлэгийн түвшин өндөр байсан.




Зураг 1. Аймгуудын санхүүгийн дундаж мэдлэг<sup>2</sup>    Зураг 2. Аймгуудын санхүүгийн бүтээгдэхүүний талаар мэдлэг

<sup>1</sup> Worldbank, USAID, “Paving the road to better Financial Decision-Making in Mongolia”, August 2013

<sup>2</sup> Судалгааны авч болох хамгийн бага үнэлгээ-0, хамгийн өндөр үнэлгээ-7


Нийт хүн амын 90 орчим хувь нь банк болон банкнаас санал болгодог бүтээгдэхүүний талаар мэдэж байсан бол 50-иас бага хувь нь даатгал болон валют арилжааны талаар, 30 хүрэхгүй хувь нь Монголын хөрөнгийн биржийн бүтээгдэхүүнүүдийн талаар мэдэж байжээ. Харин брокерын үйл ажиллагааны талаар судалгаанд оролцогчдын зөвхөн 14 хувь нь мэдлэгтэй байсан. Санхүүгийн харьцангуй олон төрлийн бүтээгдэхүүний талаар мэдлэгтэй иргэд нь мэдээллийн олон эх сурвалж ашигладаг иргэд байна. Мөн судалгаанд оролцогчдын 70 орчим хувь нь зөвхөн гурван төрлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын төрлийг мэдэж байжээ.

Санхүүгийн зан төлөв буюу төсөвлөлт хийх, санхүүгээ ирээдүйд зориулан төлөвлөх, хадгаламж, хуримтлал үүсгэх зэрэг санхүүгийн чадвартай байгаа эсэх талаар уг судалгаанаас, иргэд олж буй орлогын түвшнээс хамааран ялгаатай санхүүгийн чадвар эзэмшсэн байна. Өндөр орлоготой бүлэгтэй харьцуулахад бага орлоготой бүлгийн иргэд өдөр тутмын санхүүгээ хянаж, төсөвлөлт хийх чадвар өндөр байсан бол өндөр орлоготой иргэд нь ирээдүйд чиглэсэн санхүүгийн шийдвэр гаргах талаар илүү анхаардаг ажээ. Хүүхэд насандаа хуримтлал үүсгэх талаар мэдлэгт суралцаж эхэлсэн хүмүүс санхүүгийн чадварын хувьд илүү өндөр үнэлгээ авах хандлагатай байсан.




Зураг 3. Төсвийн хяналт, зохистой хэрэглээ Зураг 4. Ирээдүйд зориулж хуримтлал үүсгэх

Судалгаанаас, хүн амын дийлэнх хэсэг нь төсвөө хэрэгцээтэй чухал зүйлд зарцуулдаг гэсэн байна (Зураг 3). Ирээдүйд зориулсан хуримтлал үүсгэх буюу төлөвлөөгүй, гарч болзошгүй зардалд зориулан хуримтлал үүсгэх, хоол хүнс зэрэг чухал шаардлагатай зүйлсээс бусад зүйлд зориулж зээл авахгүй байх, тэтгэврийн насанд хүрэх үедээ зориулж хуримтлал үүсгэх, зохистой санхүүгийн бүтээгдэхүүн сонгох талаар хөдөө орон нутагт ажиллаж амьдардаг малчид харьцангуй доогуур үзүүлэлттэй байна (Зураг 4). Хүн амын орлогын түвшин нэмэгдэхийн хэрээр тэтгэврийн насанд зориулан хуримтлал үүсгэх, санхүүгийн зохистой бүтээгдэхүүн сонгох талаар илүү мэдлэгтэй байна.



Зураг 5. Ирээдүйд чиглэсэн шийдвэр гаргах



Зураг 6. Санаачилгатай байх

Хүн амын дийлэнх хэсэг буюу 57 хувь нь ирээдүйгээс илүү одоо байгаа нөхцөл байдалдаа илүү анхаарлаа хандуулдаг гэжээ (Зураг 5). Харин санаачилгатай байх буюу мэдээлэл, зөвлөгөө авах, бусдаас суралцах, аль болох тогтмол хадгаламж үүсгэх зэрэг үзүүлэлт бусад чадвартай харьцуулахад харьцангуй доогуур байна. (Зураг 6) Мөн тус судалгаагаар санаачилгатай байх талаар эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү идэвхтэй байдаг гэж гарсан байна.

Судалгааны үр дүнд Дэлхийн Банкны зүгээс олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх талаар холбогдох зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах, бусад шаардлагатай арга хэмжээг авахыг зөвлөсний нэг нь дэлхий нийтийн чиг хандлагаар олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх явдал юм.

Хөтөлбөрийг боловсруулахад төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх нь чухал бөгөөд энэ хүрээнд УИХ-ын 2013 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан Монголбанкны Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэлийн 3.2-т “*Иргэдийн санхүү, банкны суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Шударга, өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар зэрэг төр захиргааны байгууллагууд хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг үе шаттайгаар, нэгдсэн бодлогын хүрээнд нийгмийн давхарга, тэдгээрийн ерөнхий боловсролын түвшинтэй уялдуулан боловсруулж эхэлнэ*” мөн УИХ-ын 2014 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан Монголбанкны Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлийн 3.2-т “*Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн банкны зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх цогц арга хэмжээг эрчимжүүлнэ*” хэмээн заасан.

### 1.3. Дэлхийн хөгжлийн чиг хандлага

Олон улсын хэмжээний санхүүгийн үйл ажиллагаа нэмэгдэхийн хэрээр санал болгож буй санхүүгийн үйлчилгээ нэмэгдэж, санхүүгийн хямрал тохиовол зөвхөн нэг улс бус бүс нутгийг хамрах хандлагатай байна. Санхүү, эдийн засгийн тогтворгүй байдалтай холбогдуулан бодлого боловсруулагчдын түвшинд санхүүгийн боловсролд анхаарах талаар илүү эрчимтэй ажиллаж эхэлсэн бөгөөд энэхүү хандлага нь олон улсын бодлогын хэмжээний баримт бичигт тусгагдах болсон. Олон улсын болон бүс нутгийн хэмжээний Их 20 (G20), Ази,

Номхон далайн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Байгууллага (АРЕС), Зүүн Өмнөд Азийн Бүс Нутгийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ASEAN), Латин Америк болон Карибын Төв Банкуудын Нийгэмлэг (CEMLA), Өмнөд Африкийн Хөгжлийн Нэгдэл (SADC) болон Европын Холбоо (EU) зэрэг байгууллага болон форум санхүүгийн боловсролыг дээшлүүлэхийн ач холбогдлыг онцлох болов.

Азийн санхүүгийн хямрал, 1990-ээд оны сүүлийн үеийн санхүүгийн хямралуудын дараа буюу 2000 оноос эхлэн Япон, Голланд, Шинэ Зеланд, Сингапур, Их Британи болон АНУ зэрэг өндөр хөгжилтэй орнууд санхүүгийн боловсролыг дээшлүүлэх асуудлыг бодлогын хэмжээнд авч үзэх болсон. Эдгээр орнуудын тоо эрчимтэй нэмэгдэж байгаа бөгөөд 2011 оны байдлаар 26 орон санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шатандаа явж байсан бол 2013 оны 09 дүгээр сарын байдлаар хөгжсөн болон хөгжиж буй эдийн засагтай нийт 45 орон<sup>3</sup> олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэх стратеги гаргасан байна.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр нь үндэсний хэмжээнд санал нэгдсэн, санхүүгийн мэдлэгийг сайжруулахын тулд авч хэрэгжүүлж буй хөтөлбөр болон тогтолцоо бүхий арга хэмжээ бөгөөд дараах үе шатнаас бүрдэнэ.

- Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхийн ач холбогдлыг ойлгох, хууль эрхзүйн талаас байж болох боломжийг харах, үндэсний хэмжээнд энэхүү хөтөлбөрийн хамрах хүрээ, хэрэгцээ шаардлага зэргийг тодорхойлох;
- Үндэсний хэмжээнд зохион байгуулж, тэргүүлж ажиллах байгууллагыг тодорхойлох, хамааралтай талуудын оролцоог хангах;
- Тогтоосон хугацаанд тодорхой зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах;
- Үндэсний хэмжээний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бусад бие даасан хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах.

Үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь тухайн орны санхүүгийн зах зээлийн хөгжлийн түвшин, хүн амын хэрэгцээ шаардлага зэргээс хамааралтайгаар тодорхойлогддог. Тухайлбал, хөгжиж буй зарим орны хувьд, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн зорилго нь санхүүгийн зах зээлийг иргэдэд хүртээмжтэй болгоход чиглэдэг бол зарим нь хэрэглэгчдийг санхүүгийн шийдвэр гаргах чадавхтай болгох, хувьсаж өөрчлөгдөж байгаа нийгэм, эдийн засгийн сорилтуудтай тулгарахад нь туслах зорилготой байдаг.

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тэргүүлэн оролцох байгууллагын нөлөө чухал бөгөөд ихэнх тохиолдолд тухайн улсын Төв банк, Сангийн яам, санхүүгийн зохицуулах эрх бүхий байгууллага байдаг ба цөөн тохиолдолд үндэсний хэмжээнд санхүүгийн боловсрол олгох тусгай үүрэгтэй олон нийтийн байгууллага байдаг. Өөрөөр хэлбэл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй тусгай байгууллагыг бий болгосон байдаг. Тус байгууллагын бүтэц нь тухайн улсын улс төр, нийгмийн байгууллын тогтолцооноос шалтгаалан ялгаатай байна. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага нь үндэсний хөтөлбөрийг боловсруулахад тэргүүлэн оролцсон байгууллага болон гол оролцогч талуудын бүтцэд багтсан байдаг боловч огт өөр тусдаа байгууллага байгаа тохиолдол ч байна.

---

<sup>3</sup> Эх сурвалж: Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага (OECD)



Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг хангахад хувийн болон олон нийтийн байгууллагуудын оролцоог хангах явдал чухал юм. Хөтөлбөр хэрэгжүүлж буй бараг бүх орон хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлыг боловсролын байгууллагаар дамжуулан хийсэн байна. Мөн олон орон сонгон авсан зорилтот хэсэгт мэдээлэл түгээхийн тулд тусгай цахим хуудас болон зарим тохиолдолд хэрэглэгчдэд зөвлөгөө өгөх төвүүдийг ажиллуулдаг ажээ.

#### 1.4. Санхүүгийн мэдлэгийн талаар тодорхойлолт

Санхүүгийн мэдлэг гэдэг нь иргэн тухайн эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалд тохируулан өөрийн санхүүг зөвөөр удирдах мэдлэг, чадвар болон итгэл үнэмшилтэй байхыг хэлнэ. Энд:

- “Мэдлэг” гэдэг нь иргэн хувийн санхүүгийн талаар ойлгодог байх;
- “Чадвар” гэдэг нь санхүүгийн талаар мэдлэгээ өөрийн санхүүг удирдахад ашиглах;
- “Итгэл үнэмшил” гэдэг нь хувийн санхүүгийн шийдвэр гаргахдаа өөртөө бүрэн итгэлтэй байхыг тус тус хэлнэ.

Санхүүгийн мэдлэг олгох үйл явцад дараах зүйлс хамаарахгүй. Үүнд:

- Санхүүгийн бүтээгдэхүүний сурталчилгаа. Тухайлбал, тодорхой нэг бүтээгдэхүүн болон брэндийг сурталчлах гэх мэт;
- Арилжааны шинжтэй санхүүгийн зөвлөгөө. Тухайлбал, тухайн зөвлөгөө нь тодорхой нэг байгууллагын тухайлсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох гэх мэт.

Санхүүгийн мэдлэгийн хамрах хүрээ нь ямар нэг бизнесийг хэрхэн удирдах талаар бус *зөвхөн хувь хүний санхүүг удирдах талаар* байна. Гэвч хувь хүний санхүүгийн удирдлага сайжрах нь цаашид амжилттайгаар бизнес удирдан явуулахад чухал алхам болдог.

#### 1.5. Хөтөлбөрийн ач холбогдол

Иргэдийн санхүүгийн мэдлэг сайжрах нь эдийн засгийн бодит өсөлт болон ядуурлыг бууруулахад чухал нөлөөтэйгөөс гадна хэрэглэгчид, санхүүгийн үйлчилгээний салбар, засгийн газар, төв банк, бусад санхүүгийн зохицуулах үүрэг бүхий байгууллагууд, боловсрол олгогчид, ажил олгогч, ажиллагчид болон сайн дурын байгууллагууд зэрэг олон оролцогч талуудад ашиг тусаа өгдөг.

Санхүүгийн боловсрол нэмэгдсэнээр дараах гол үр дүн гарна.

- Иргэдийн мэдлэг дээшилснээр санхүүгийн бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэнэ;
- Иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн сонгох боломжтой болно;
- Санхүүгийн залилан, мэхлэлээс урьдчилан сэргийлэх явдал нэмэгдэж, түүнд өртөх иргэдийн тоо буурна;
- Иргэдийн хадгаламж нэмэгдэж, өр багасна;
- Хувь хүний ажлын бүтээмж нэмэгдэнэ;
- Хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн тоо өснө;
- Ядуурал, гэмт хэрэг буурна.

## **1.6. Хөтөлбөрийн алсын хараа болон зорилт**

**1.6.1 Хөтөлбөрийн алсын хараа:** Монгол Улсын иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ зохистой удирдах мэдлэг, чадвар болон итгэл үнэмшилтэй болно.

### **1.6.2 Хөтөлбөрийн зорилт:**

- Иргэдийн хувийн санхүүгээ зохистой удирдах чадварыг дээшлүүлэх;
- Иргэдийг санхүүгийн залилангаас өөрийгөө хамгаалах чадвартай болгох;
- Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ажлын байгаа нөөц бололцоог зөв, үр ашигтай зарцуулан зохион байгуулах;
- Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд оролцож байгаа байгууллага болон хувь хүмүүс үр дүнтэй хамтран ажиллах, мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх болно.

## **1.7. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим**

Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

- Үндэсний хөгжлийн цогц бодлогын үзэл баримтлалд тулгуурлах;
- Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл зэрэг эдийн засаг, санхүүгийн салбарын хөгжилтэй холбоотой гарсан бодлогын бусад баримт бичгүүдтэй уялдуулах, залгамж чанарыг хадгалах;
- Санхүүгийн мэдлэг олгох үйл ажиллагаа нь шударга, аливаа үл ялгаварлан гадуурхах асуудалгүй байна;
- Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах;
- Олон улсын жишигт нийцсэн байх;
- Олон төрлийн арга хэрэгслээс үр ашигтайг сонгон ашиглах;
- Хамгийн чухал арга хэмжээг эрэмбэлэн тогтоох;
- “Сургах мөчүүд” буюу гэрлэлт, хүүхэдтэй болох, тэтгэвэрт гарах зэрэг санхүүгийн шийдвэр гаргах амьдралын мөчлөгийг харгалзан үзэх;
- Хүйсийн тэгш байдлыг харгалзах;
- Нөөцийг үр ашигтай зарцуулах;
- Өмнө нь авч хэрэгжүүлж байсан арга хэмжээнүүд дээр үндэслэх;
- Хэрэглэгчдэд зориулсан арга хэмжээг хэрэгжүүлэхээсээ өмнө шалгаж, турших.

## **1.8. Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл**

Олон улсын туршлагаас, олон төрлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Гэвч хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөөц бололцоо хязгаарлагдмал байдаг тул хамгийн үр нөлөө бүхий тэргүүлэх чиглэлүүдийг эхний ээлжинд сонгон хэрэгжүүлэх нь чухал юм.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг дараах 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1.8.1 Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох;
- 1.8.2 Залуу үед санхүүгийн мэдлэг олгох;
- 1.8.3 Хөдөө, орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
- 1.8.4 Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох.

## 1.9. Хөтөлбөрийн хүрээнд мэдлэг олгох сэдэв

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах гол сэдэвт чиглэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн талаар суурь ойлголт;
- Төсөв болон санхүүгийн төлөвлөлт;
- Хадгаламж;
- Зээл;
- Хөрөнгө оруулалт;
- Санхүүгийн эрсдлээс хамгаалах;
- Даатгал, урт хугацааны даатгал;
- Тэтгэврийн хуримтлал үүсгэх;
- Нийгмийн даатгал болон татварын талаар ойлголт;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаар ойлголт.

## 1.10. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт, тайлагнал

1.10.1 Хөтөлбөрийг 2016-2021 онуудад хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

I үе шат: 2016-2019 он

II үе шат: 2019-2021 он

1.10.2 Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг гардан зохион байгуулах бөгөөд мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангана.

1.10.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд дараах байдлаар хамтарч ажиллана.

- Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх талаар бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх, ивээн тэтгэх;
- Судалгаа, шинжилгээ хийх болон техникийн туслалцаа үзүүлэх;
- Сургалт зохион байгуулах, чадавхыг бэхжүүлэх талаар хамтарч ажиллах;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, үнэлгээг хийхэд хамтарч ажиллах;
- Нөөц бололцоо, мэдээ, мэдээлэл зэргийг үр ашигтайгаар хуваан ашиглах;
- Хамтран ажиллах боломжтой бусад байгууллагуудыг үйл ажиллагаандаа татан оролцуулах.

1.10.4 Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлд шинэ нөхцөл, байдал үүссэн тохиолдолд хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн баталж болно.

1.10.5 Хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан УИХ-ын ЭЗБХ-нд танилцуулна.

## 1.11. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт санхүүгийн суурь мэдлэг олгох агуулга багтсан байна.
- Их, дээд сургуулийн оюутнуудын сургалтын хөтөлбөрт санхүүгийн мэдлэг олгох агуулга багтсан байна.
- Иргэдийн хувийн санхүүгийн талаар мэдлэг буюу хяналттай төсөвлөлт хийх, ирээдүйн хэрэгцээнд зориулж нөөц, хуримтлал үүсгэх, урьтаж байх, ирээдүйн тухай тунгаах чадамж дээшилсэн байна.
- Хадгаламжтай иргэдийн тоо нэмэгдсэн байна.
- Хөрөнгийн зах зээлд иргэдээс оруулж буй хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.
- Даатгалтай иргэдийн тоо нэмэгдсэн байна.
- Иргэдийн хугацаа хэтэрсэн, найдваргүй өрийн хэмжээ буурна.
- Нэг хүний хэрэглэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний дундаж тоо нэмэгдсэн байна.
- Санхүүгийн бүтээгдэхүүнийг мэдээлэл, мэдлэг дээр үндэслэн зөвөөр сонгох байдал нэмэгдэнэ.
- Санхүүгийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдлэг нэмэгдсэн байна.
- Санхүүгийн зах зээлд оролцогчдын хоорондох мэдээллийн урсгал сайжирсан байна.
- Санхүүгийн залиланд өртсөн иргэдийн тоо буурна.

## 1.12. Хөтөлбөрийн санхүүжилт

1.12.1 Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөс гадна гадаад дотоодын хандив, тусламж хийгээд бусад хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлж ажиллана.

1.12.2 Санхүүжилтийг хийхдээ төсвийг үр ашигтай зарцуулах байдлыг үндэс болгоно. Үүнд:

1.12.2.1 Тэргүүлэх чиглэлийн хүрээнд аливаа үйл ажиллагааг өмнө хэрэгжиж байсан ижил төрлийн үйл ажиллагаанд суурилж, цааш үргэлжлүүлэх байдлаар хэрэгжүүлнэ.

1.12.2.2 Шаардлагагүй давхардал үүсэхээс сэргийлнэ.

1.12.2.3 Монголбанк бусад оролцогч талтай хамтран хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх байгууллагуудтай холбоо тогтоож, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлж ажиллана.

## 1.13. Хөтөлбөрийн үр дүнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ

1.13.1 Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд холбогдох мэргэжлийн болон судалгааны, түүнчлэн төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор нэгдсэн төлөвлөгөөний үндсэн дээр хийх бөгөөд зохих зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

1.13.2 Хөтөлбөрийн үр дүнг үнэлэхдээ зорилтот хөтөлбөр нь зорилтот бүлэгт хүрч санхүүгийн мэдлэгийн түвшин нэмэгдсэн эсэх болон нөөцийг үр ашигтай зарцуулсан

эсэхэд хяналт үнэлгээг төвлөрүүлэн хийх ба ингэснээр хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг үйл ажиллагаа цаашид сайжруулах боломж олгох юм. Мөн хөрөнгө оруулагчдад санхүүжилтийг хэрхэн зарцуулсан талаар мэдээллээр хангаж цаашдын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ямар төрлийн үйл ажиллагаанд оруулах талаар шийдвэр гаргахад чухал үүрэгтэй.

1.13.3 Хөтөлбөрийн үнэлгээг дараах хоёр үе шаттай хийнэ.

I үе шат: Бодлогын зорилтын эхний шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 30-ны өдөр);

II үе шат: Бодлогын зорилтын дунд шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр);

1.13.4 Хөтөлбөрт тусгагдсан зорилго бүрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт байх бөгөөд гол анхаарал хандуулах зарим зорилгын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг салбар тус бүрээр урьдчилан тодорхойлсон байна.


1.13.5 Хяналт үнэлгээг хөтөлбөрийн хэмжээнд нийтэд нь хийхэд нарийвчилсан үр дүнг харахад хүндрэлтэй байдаг учраас доор дурдсан хоорондоо ялгаатай аргаар зэрэгцүүлсэн үнэлгээг хийнэ.

1.13.5.1 Хөтөлбөр хэрэгжихээс өмнө улсын хэмжээнд авсан санхүүгийн боловсролын талаар судалгааг хөтөлбөрийн үе шат бүрд давтан хийж, үр нөлөөг үнэлнэ.

1.13.5.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцсон байгууллагууд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа бүрийн үр дүнд үнэлгээг хийх ба үүнд Монголбанк аргазүйн туслалцаа үзүүлнэ.

1.13.5.3 Өр, хадгаламжийн хэмжээ, ажилгүйдэл, ядуурлын судалгаа зэрэг судалгааны хоёрдогч эх сурвалжид үндэслэн тоон шинжилгээг хийх ба хөтөлбөрт хамрагдсан иргэд, авч хэрэгжүүлсэн гол арга хэмжээнүүдийн тоо, эдгээрээс гарсан арга хэмжээний талаар цуглуулсан мэдээ, мэдээллийг нэгтгэж оролцогч талуудад түгээнэ.

## ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



## 2.1.1 Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд

- Үндэслэл:**
- Монгол Улсын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2012-2016 оны тэргүүлэх чиглэлүүд /хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө/-д боловсролын агуулга, стандарт, хөтөлбөр, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, орчин, хүний нөөцийн чадавхыг олон улсын жишигт нийцсэн уян хатан, өрсөлдөх чадвартай тогтолцоо болгон хөгжүүлэхийн зэрэгцээ Монгол хүнийг төлөвшүүлэхэд онцгой анхаарна гэж заасан.
  - Хувь хүний санхүүгийн суурь ойлголттой болж, төлөвших нас нь хүүхэд наснаас эхэлдэг тул энэ үед санхүүгийн суурь ойлголтуудын талаар үнэн бодитой, зөв мэдээлэл өгөх нь чухал юм.
  - Манай улсын хувьд дунд сургуульд хамрагдалтын түвшин өндөр байдаг тул хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан санхүүгийн мэдлэг олгоход бүхэл бүтэн үеийг хамруулж болох гол ач холбогдолтой.
  - Хүүхдүүдийн санхүүгийн боловсрол дээшлэх нь эцэг эхийн санхүүгийн боловсролд эерэг нөлөө үзүүлдэг.
  - Одоогийн байдлаар дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт санхүү, эдийн засгийн холбогдолтой сэдвүүд багтаж байгаа боловч харьцангуй макро эдийн засгийн хүрээний асуудлыг хамарсан, өрхийн болон хувийн санхүүг хэрхэн зөв зохистой удирдах талаар бага тусгагдсан. ҮСХ-ноос хийсэн Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторингийн сурах бичгүүдийн агуулгад хийсэн судалгаанаас Эдийн засгийн мэдээлэл дунд сургуулийн анхлах ангиудын сургалтын хөтөлбөрт багтсан байдаг боловч “Үйлдвэрлэгч ба хэрэглэгч”, “Мөнгө”, “Татвар”, “Эдийн засгийн тогтолцоо”, “Эдийн засаг, зах зээлийн эдийн засгийн тухай ойлголт”, “Эрэлт, нийлүүлэлт”, “Үнэ”, “Өрсөлдөөн”, “Ажилгүйдэл”, “Инфляци” зэрэг цөөн тооны макро эдийн засгийн сэдвүүдийг голлон хамарсан байна.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт бага наснаасаа эхлэн хадгаламжтай болгох, хувийн санхүүгээ удирдаж сурах зэрэг санхүү, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах талаар анхан шатны ойлголт, мэдлэг өгөх агуулгыг багтаах;
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулахад техникийн туслалцаа үзүүлэх болон санхүүжилт олох талаар хамтарч ажиллах;
- Санхүүгийн мэдлэг олгох талаар ерөнхий боловсролын сургуулийн багш нарын чадавхыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, холбогдох ном, гарын авлагыг боловсруулах;
- Телевизийн хүүхдийн нэвтрүүлгийн хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах;
- Санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх талаар хүүхдийн нэвтрүүлэг бэлдэж буй сэтгүүлчдийг сургалтад хамруулах, чадавхыг нэмэгдүүлэх;

- Хэрэгжүүлэх үйл ажиллагаанд санхүүжилт олоход оролцогч талууд хамтран ажиллах;
- Хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд нь сургуулийн насны хүүхдүүдийн санхүүгийн боловсролд хэрхэн нөлөөлж байгаад хяналт, үнэлгээг хийх;

### 2.1.2 Залуу үед санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд

#### Үндэслэл:

- *Санхүүгийн голлох шийдвэр гаргаж, санхүүгийн зах зээлд идэвхтэй оролцож эхэлдэг үе нь залуу үе буюу 18-25 насныхан байдаг учраас энэхүү насны бүлэгт санхүүгийн мэдлэг олгох нь ач холбогдол өндөртэй байдаг. Манай улсын хувьд нийт хүн амын 30 гаруй хувийг 18-25 насны залуучууд эзэлж байна.*
- *18-25 насныхны хувь ЕБС-ийн хөтөлбөр болон их сургуулийн сургалтын хөтөлбөрөөс санхүүгийн боловсролын талаар төдийлөн мэдээлэл аваагүйн дээр санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, хэрэглээ өргөжиж байгаа энэ үед тус зорилтот бүлэгт анхаарал хандуулах нь зайлиггүй чухал юм.*
- *Гэрлэлт, шинэ ажилд орох, шинээр бизнес эрхлэх зэрэг “Сургах мөчүүд” буюу хүн өөрийн амьдралдаа шууд тусган, шинэ мэдээлэл шингээж чадах үе нь залуу үед голчлон тохиолддог.*

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Оюутан залууст хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан санхүүгийн боловсрол олгох, их сургуулийн заавал үзэх суурь хичээлийн хөтөлбөрт санхүүгийн мэдлэг олгох сэдвээр тусгах талаар их сургуулиудтай хамтран ажиллах;
- Залууст зориулсан лекц, соёл, олон нийтийн үйл ажиллагааг хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудтай хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулах;
- Шинэ, залуу гэр бүлд санхүүгийн мэдлэг олгох сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан хийх;
- Хэрэгжүүлэх үйл ажиллагаанд санхүүжилт олоход оролцогч талууд хамтран ажиллах;
- Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь зорилтот бүлгийн санхүүгийн боловсролд хэрхэн нөлөөлж байгаад хяналт, үнэлгээг хийх

### 2.1.3 Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд

#### Үндэслэл:

- *Хөдөө орон нутгийн иргэд хот суурин газартай харьцуулахад алслагдсан, мэдээлэл авах боломж бага байдгаас өөрт тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн сонгох, санхүүгийн бусад үйл ажиллагаанд оролцох зэрэгт хүндрэлтэй тулгардаг.*
- *Тэтгэврийн насанд хүрэх үедээ зориулж хуримтлал үүсгэх, зохистой санхүүгийн бүтээгдэхүүн сонгох талаар хөдөө орон нутагт ажиллаж амьдардаг малчид мэдлэг дутмаг байна.*

#### Хэрэгжүүлэх үйл

- Орон нутгийн иргэдэд дутагдалтай байгаа, сайжруулах нэн шаардлагатай санхүүгийн мэдээллийн талаар судалгаа хийж, тогтоох;



## ажиллагаа

- Орон нутаг дахь төрийн болон төрийн бус байгууллагын сүлжээг ашиглан орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох; (Тухайлбал аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, бүртгэл хариуцсан ажилтан нь СЗХ-ны Орон нутгийн төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэдэг. Тиймээс тэдгээр орон нутгийн төлөөлөгчдийг зөвлөх хэлбэрээр ажиллуулан санхүүгийн боловсролын талаар мэдээлэл түгээх);
- Санхүүгийн зах зээлтэй холбогдолтой аливаа хууль эрхзүйн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, санхүүгийн суурь мэдлэг олгох, өөрсдийн эрх ашгийг хамгаалах, тохиромжтой санхүүгийн бүтээгдэхүүн сонгох зэрэг ур чадварыг нэмэгдүүлэх талаар тусгай албан бус сургалтын хөтөлбөр боловсруулан, орон нутгийн иргэдэд сургалт явуулах сургагч багш бэлтгэж, тусгайлсан сургалт зохион байгуулах;
- Орон нутаг дахь төрийн болон төрийн бус байгууллагын сүлжээгээр дамжуулан сургалт хийхэд зориулсан сургалтын гарын авлага, тараах материал боловсруулах;
- Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр уулзалт зохион байгуулж, тухайн орон нутгийн захиргаа, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах;
- Хэрэгжүүлэх үйл ажиллагаа санхүүжилт олоход оролцогч талууд хамтран ажиллах;
- Хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд нь зорилтот бүлгийн санхүүгийн боловсролд хэрхэн нөлөөлж байгаад хяналт, үнэлгээг хийх.

### 2.1.4 Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд

#### Үндэслэл:

- *Интернет хэрэглэгчид, ухаалаг утас хэрэглэгчдийн тоо сүүлийн жилүүдэд эрчимтэй өсч байгаа.*
- *Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн сүлжээгээр мэдээлэл түгээх нь бага зардлаар олон хүнийг хамруулах ач холбогдолтой байдаг.*
- *Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх нэгдсэн цахим хуудас ажиллуулснаар иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах мэдээ, мэдээллээс гадна хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг оролцогч талуудад мэдээлэх, үйл ажиллагаанд хяналт тавих боломж олгоно.*
- *Хөдөө орон нутгийн иргэд, малчид олон нийтийн телевиз, радио, сонин сэтгүүлээр голлон мэдээлэл авдаг.*

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Санхүүгийн боловсролыг дэмжих нэгдсэн цахим хуудас ажиллуулах; Энэхүү цахим хуудас нь иргэдэд санхүүгийн мэдлэг олгоход чиглэсэн байх бөгөөд цахим хуудсанд санхүүгийн боловсрол олгох мэдээллүүдээс гадна холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн оролцогч, аж ахуйн нэгжүүдтэй холбоотой мэдээ мэдээллийг байршуулна.

- Холбогдох санхүүгийн тооцоолол хийх програмуудыг боловсруулж, санхүүгийн боловсролыг дэмжих нэгдсэн цахим хуудсанд байрлуулах;
- Мөн тухайн цахим хуудсаараа дамжин иргэдээс тогтмол санал асуулга авч, шаардлагатай мэдээллийн агуулгыг тодорхойлно.
- Тусгай дугаарын лавлах утас ажиллуулах, гар утсаар дамжуулан мэдээлэл түгээх; Энэхүү тусгай дугаарын утсаар иргэдийг санхүүгийн салбарын мэдээллээр хангаж, тэдний гомдол, хүсэлтийг хүлээн авч холбогдох байгууллагуудад хүргүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавих бөгөөд цаашлаад санал, гомдлын агуулгад тулгуурлан иргэдэд шаардлагатай байгаа санхүүгийн мэдээллийн агуулгыг тодорхойлоход ашиглах;
- Телевиз, сонин, сэтгүүл, радио гэсэн уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй санхүүгийн боловсрол олгох зорилготой нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэн явуулах талаар хамтран ажиллах;
- IPTV-г ашиглаж, видео санд санхүүгийн мэдлэгийн тусгай цэс нээн ажиллуулна. Ингэснээр тус санд иргэдэд санхүүгийн мэдлэг олгох агуулга бүхий олон ангит кино, нэвтрүүлэг, богино хэмжээний зохиомж зэрэг бүхий л хэлбэрийн мэдээллийг багтаах боломжтой болно.
- Санхүүгийн боловсролын талаар мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэдэг сэтгүүлчдэд зориулсан сургалт явуулах;
- Хэрэгжүүлэх үйл ажиллагаанд санхүүжилт олоход оролцогч талууд хамтран ажиллах;
- Хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд нь зорилтот бүлгийн санхүүгийн боловсролд хэрхэн нөлөөлж байгаад хяналт, үнэлгээг хийх

